



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/289

Улаанбаатар хот

Нийслэлийн Багахангай дүүргийн
“Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу Багахангай дүүргийн “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон нийт 4,768,040 (дөрвөн сая долоон зуун жаран найман мянга дөч) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Багахангай дүүргийн “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ (Н.Дамдинрагчаа)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 4,768,040 (дөрвөн сая долоон зуун жаран найман мянга дөч) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 102,000 (нэг зуун хоёр мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 30,600 (гучин мянга зургаан зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Багахангай дүүргийн “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ (Н.Дамдинрагчаа)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000843



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн 4089 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багахангай дүүргийн Багахангай тохижилт ОНӨААТҮГ

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨАУ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХХК-н шийдвэр
1	Хороо захираганы байрны гэрэлтүүлэг	7	ш	1	1,000,000	1,000,000	1,000,000	-	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон.	актлаж данс бүртгэлээс хасах	10,000	10,000	
2	Ачааны мопед	8	ш	2	1,115,520	2,231,040	2,231,040	-	Ашиглалтын шаардлага хангахгүй шатсан.	актлаж данс бүртгэлээс хасах	60,000	60,000	
3	Принтер /Samsung Xpress M2020/	5	ш	1	120,000	120,000	120,000	-	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон.	актлаж данс бүртгэлээс хасах	4,000	4,000	
4	Өнгөт принтер /Epson Me Office 620F/	5	ш	1	460,000	460,000	460,000	-	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон.	актлаж данс бүртгэлээс хасах	10,000	10,000	
5	Компьютер /Dell Optiplex 3010/	8	ком	1	957,000	957,000	957,000	-	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон.	актлаж данс бүртгэлээс хасах	18,000	18,000	
Тоног төхөөрөмжийн дүн													
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн													
Үүнээс. Худалдах хөрөнгө						4,768,040	4,768,040	4,768,040					
Актлах хөрөнгө													
Татан төвлөрүүлэн хөрөнгө						-	-	-					
Худалдсанаас олох орлого													
НӨАУ-т төвлөрүүлэх /30%/													
						102,000	102,000	102,000					
						30,600	30,600	30,600					